

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
БШУС	Боловсрол шинжлэх ухааны сайд
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	13
3.Аудитын тайлан.....	14
3.1. Ерөнхий зүйл.....	14
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	14
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	15
3.4. Материаллаг байдал	15
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	15
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	17
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	18
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
3.9. Аудитын илрүүлэлт.....	19
Залруулсан алдаа.....	19
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	19
Аудитын зөвлөмж.....	20
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	20
4. Менежментийн захидал.....	21
5.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	23



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ФИЗИК ТЕХНОЛОГИЙН
ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРАЛ
П.АЛТАНЦОГ ТАНАА

0004.02.05 № 07/561
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Физик технологийн хүрээлэнгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Физик технологийн хүрээлэнгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 25 зорилтын хүрээнд 47 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 95.6 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Аудитын гол асуудал

Санхүүгийн байдлын тайлан дахь 222,545.1 мянган төгрөгийн бараа материалыг 2020 оны жилийн эцэст тооллого хийж, тооцоо бодоогүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-д “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ: 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.2-д “түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа

\\10.10.10.20\Bichia Khurel\Yawsan Bichia\2021\0225auditin 2-R Gazar82.Docx

001051132

боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1,12 дугаар сарын 1-нээс/ тооллого хийх” гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй, үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>199,436,126.87</u>	<u>267,259,898.46</u>
33	АВЛАГА	-	714,797.39
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	158,062.79
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	556,734.60
34	УРЬДЧИЛГАА	-	44,000,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	-	44,000,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	199,436,126.87	222,545,101.07
351	Түүхий эд материал	174,494,676.87	201,515,994.27
35110	Тусгай зориулалттай материал	174,494,676.87	201,515,994.27
354	Хангамжийн материал	24,941,450.00	21,029,106.80
35410	Бичиг хэргийн материал	15,426,603.00	6,088,939.00
35420	Аж ахуйн материал	9,514,847.00	14,940,167.80
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>5,063,010,957.05</u>	<u>5,208,624,726.37</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,063,010,957.05	5,208,624,726.37
392	Биет хөрөнгө	4,779,265,017.05	4,924,878,786.37
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,212,379,176.30	4,212,379,176.30
39202	Хуримтлагдсан элэгдэл	(165,967,573.82)	(283,430,009.66)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	21,495,833.25	21,495,833.25
39204	Хуримтлагдсан элэгдэл	(8,240,069.40)	(11,822,708.28)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	2,381,688,987.06	1,652,682,797.80
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,944,161,852.74)	(923,739,285.74)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	372,888,433.00	374,418,673.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(105,297,079.50)	(131,584,853.20)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	203,910.00	203,910.00
39217	Ном	14,275,252.90	14,275,252.90
393	Биет бус хөрөнгө	283,745,940.00	283,745,940.00
39301	Програм хангамж	4,601,840.00	4,601,840.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(4,601,840.00)	(4,601,840.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	283,745,940.00	283,745,940.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>5,262,447,083.92</u>	<u>5,475,884,624.83</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	=	=
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>5,262,447,083.92</u>	<u>5,475,884,624.83</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	5,262,447,083.92	5,475,884,624.83
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,804,884,082.53	2,804,884,082.53
51101	Өмч: - төрийн	2,804,884,082.53	2,804,884,082.53
512	Хуримтлагдсан үр дүн	(1,442,365,022.36)	(1,228,927,481.45)
51210	Өмнөх үеийн үр дүн	(1,442,365,022.36)	(1,442,365,022.36)
51220	Тайлант үеийн үр дүн	-	213,437,540.91
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,899,928,023.75	3,899,928,023.75
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>5,262,447,083.92</u>	<u>5,475,884,624.83</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,170,514,054.00	2,366,101,121.42
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	437,050,644.00	429,778,351.42
120	Нийтлэг татварын бус орлого	437,050,644.00	429,778,351.42
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	437,050,644.00	429,778,351.42
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	18,510,644.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө		20,875,470.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	418,540,000.00	408,902,881.42
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,733,463,410.00	1,936,322,770.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,493,597,000.00	1,774,890,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,493,597,000.00	1,774,890,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	239,866,410.00	161,432,470.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	12,642,410.00	18,150,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	227,224,000.00	135,624,200.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	7,658,270.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,983,527,821.52	2,152,663,580.51
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,983,527,821.52	2,152,663,580.51
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,979,409,254.91	2,131,334,451.04
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,106,600,900.00	1,337,556,469.00
210101	Үндсэн цалин	978,100,700.00	1,009,271,843.00
210102	Нэмэгдэл	118,607,900.00	231,883,899.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,892,300.00	96,400,727.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	137,041,862.00	163,788,109.21
210201	Тэтгэврийн даатгал	85,670,962.00	131,445,104.81
210202	Тэтгэмжийн даатгал	12,842,700.00	12,716,742.21
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,274,200.00	1,902,875.70
210204	Ажилгүйдлийн даатгал	2,568,500.00	376,531.88
210205	Эрүүл мэндийн даатгал	25,685,500.00	17,346,854.61
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	53,024,048.93	77,214,032.00
210301	Гэрэл, цахилгаан	24,873,066.94	41,607,933.96
210302	Түлш, халаалт	25,539,669.37	32,262,116.34
210303	Цэвэр, бохир ус	2,611,312.62	3,343,981.70
2104	Хангамж, бараа материалын зардал	33,998,391.61	14,493,641.73
210401	Бичиг хэрэг	11,056,270.00	5,672,225.00
210402	Тээвэр, шатахуун	950,000.00	704,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,862,668.61	1,831,229.53

210404	Ном, хэвлэл	731,800.00	333,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,380,000.00	1,380,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	18,017,653.00	4,573,087.20
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	25,411,190.00	16,080,642.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	180,000.00	-
210604	Урсгал засвар	25,231,190.00	16,080,642.00
2107	Томилолт, зочны зардал	2,000,000.00	-
210702	Дотоод албан томилолт	2,000,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	279,653,258.91	174,539,279.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	275,929,421.91	170,815,442.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,980,000.00	1,980,000.00
210807	Газрын төлбөр	1,743,837.00	1,743,837.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	341,679,603.46	347,662,278.10
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	2,240,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	341,679,603.46	345,422,278.10
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,118,566.61	21,329,129.47
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,094,300.00	4,270,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,094,300.00	4,270,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	24,266.61	17,059,129.47
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	17,059,129.47
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,340.46	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>186,986,232.48</u>	<u>213,437,540.91</u>
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	37,835,178.00	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	33,591,008.00	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	4,244,170.00	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(37,835,178.00)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>149,151,054.48</u>	<u>213,437,540.91</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,751,974,054.00	1,936,322,770.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	18,492,816.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	18,492,816.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	18,492,816.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	18,492,816.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,733,481,238.00	1,936,322,770.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,493,597,000.00	1,774,890,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,493,597,000.00	1,774,890,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	239,884,238.00	161,432,470.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	12,642,410.00	18,150,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	227,224,000.00	135,624,200.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	17,828.00	7,658,270.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,654,937,615.00	1,875,065,074.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,654,937,615.00	1,875,065,074.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,650,819,048.39	1,853,179,209.93
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,106,600,900.00	1,337,556,469.00
210101	Үндсэн цалин	978,100,700.00	1,009,271,843.00
210102	Нэмэгдэл	118,607,900.00	231,883,899.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,892,300.00	96,400,727.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	137,041,862.00	163,946,172.00
210201	Тэтгэврийн даатгал	85,670,962.00	131,603,167.60
210202	Тэтгэмжийн даатгал	12,842,700.00	12,716,742.21
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,274,200.00	1,902,875.70
210204	Ажилгүйдлийн даатгал	2,568,500.00	376,531.88
210205	Эрүүл мэндийн даатгал	25,685,500.00	17,346,854.61
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	-	-
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	53,024,048.93	77,214,032.00
210301	Гэрэл, цахилгаан	24,873,066.94	41,607,933.96
210302	Түлш, халаалт	25,539,669.37	32,262,116.34
210303	Цэвэр, бохир ус	2,611,312.62	3,343,981.70
2104	Хангамж, бараа материалын зардал	18,273,977.61	18,463,329.53
210401	Бичиг хэрэг	2,744,700.00	3,615,000.00
210402	Тээвэр, шатахуун	950,000.00	704,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,862,668.61	1,831,229.53
210404	Ном, хэвлэл	731,800.00	333,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,380,000.00	1,380,000.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,604,809.00	10,600,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	32,215,980.00	59,455,030.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	215,980.00	44,000,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	1,365,030.00
210604	Урсгал засвар	32,000,000.00	14,090,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,000,000.00	-
210702	Дотоод албан томилолт	2,000,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	301,662,279.85	194,304,177.40
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	297,938,442.85	190,580,340.40
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,980,000.00	1,980,000.00
210807	Газрын төлбөр	1,743,837.00	1,743,837.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	2,240,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	2,240,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,118,566.61	21,885,864.07
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,094,300.00	4,270,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,094,300.00	4,270,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	24,266.61	17,615,864.07
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	17,059,129.47
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>97,036,439.00</u>	<u>61,257,696.00</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	≡	≡
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	97,036,439.00	61,257,696.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	97,036,439.00	61,257,696.00
2200	Дотоод эх үүсвэрээр	97,036,439.00	61,257,696.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	97,036,439.00	61,257,696.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(97,036,439.00)</u>	<u>(61,257,696.00)</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	≡	≡
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	≡	≡
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,804,884,082.53	3,899,928,023.75	(1,591,516,076.80)	5,113,296,029.48
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	149,151,054.48	149,151,054.48
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,804,884,082.53	3,899,928,023.75	(1,442,365,022.32)	5,262,447,083.92
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,804,884,082.53	3,899,928,023.75	(1,442,365,022.36)	5,262,447,083.92
Тайлант үеийн үр дүн	-	-	213,437,540.91	213,437,540.91
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,804,884,082.53	3,899,928,023.75	(1,228,927,481.45)	5,475,884,624.83

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,774,890,300.00	1,757,831,170.53	(17,059,129.47)	99.04
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,774,890,300.00	1,757,831,170.53	(17,059,129.47)	99.04
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,770,620,300.00	1,753,561,170.53	(17,059,129.47)	99.04
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,337,604,600.00	1,337,556,469.00	(48,131.00)	100.00
210101	Үндсэн цалин	980,066,800.00	1,009,271,843.00	29,205,043.00	102.98
210102	Нэмэгдэл	221,630,600.00	231,883,899.00	10,253,299.00	104.63
210103	Унаа хоолны хөнгөлөлт	135,907,200.00	96,400,727.00	(39,506,473.00)	70.93
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	180,527,900.00	163,946,172.00	(16,581,728.00)	90.81
210201	Тэтгэврийн даатгал	124,305,100.00	131,603,167.60	7,298,067.60	105.87
210202	Тэтгэмжийн даатгал	14,055,700.00	12,716,742.21	(1,338,957.79)	90.47
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,244,600.00	1,902,875.70	(9,341,724.30)	16.92
210204	Ажилгүйдлийн даатгал	2,811,100.00	376,531.88	(2,434,568.12)	13.39
210205	Эрүүл мэндийн даатгал	28,111,400.00	17,346,854.61	(10,764,545.39)	61.71
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	76,009,000.00	76,009,000.00	-	100.00
210301	Гэрэл, цахилгаан	38,120,000.00	40,402,901.96	2,282,901.96	105.99
210302	Түлш, халаалт	35,489,000.00	32,262,116.34	(3,226,883.66)	90.91
210303	Цэвэр, бохир ус	2,400,000.00	3,343,981.70	943,981.70	139.33
2104	Хангамж, бараа материалын зардал	17,591,900.00	17,281,029.53	(310,870.47)	98.23
210401	Бичиг хэрэг	2,820,000.00	2,820,000.00	-	100.00
210402	Тээвэр, шатахуун	704,100.00	704,100.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,142,100.00	1,831,229.53	(310,870.47)	85.49
210404	Ном, хэвлэл	223,000.00	223,000.00	-	100.00

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,102,700.00	1,102,700.00	-	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,600,000.00	10,600,000.00	-	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	56,400,000.00	56,400,000.00	-	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	45,000,000.00	45,000,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	11,400,000.00	11,400,000.00	-	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	100,486,900.00	100,368,500.00	(118,400.00)	99.88
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	97,191,900.00	97,073,500.00	(118,400.00)	99.88
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,980,000.00	1,980,000.00	-	100.00
210807	Газрын төлбөр	1,315,000.00	1,315,000.00	-	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000.00	2,000,000.00	-	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,000,000.00	2,000,000.00	-	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,270,000.00	4,270,000.00	-	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,270,000.00	4,270,000.00	-	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,270,000.00	4,270,000.00	-	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,774,890,300.00	1,757,831,170.53	(17,059,129.47)	99.04
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,774,890,300.00	1,757,831,170.53	(17,059,129.47)	99.04
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,774,890,300.00	1,757,831,170.53	(17,059,129.47)	99.04
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	118	108	(10)	91.53
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	97	90	(7)	92.78
620003	Үйлчлэх ажилтан	20	17	(3)	85.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		161,432,470.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		161,432,470.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		160,875,735.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		1,205,032.00
210301	Гэрэл, цахилгаан		1,205,032.00
2104	Хангамж, бараа материалын зардал		1,182,300.00
210401	Бичиг хэрэг		795,000.00
210404	Ном, хэвлэл		110,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		277,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		4,055,030.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		1,365,030.00
210604	Урсгал засвар		2,690,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		154,193,373.40
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		153,764,536.40
210807	Газрын төлбөр		428,837.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		240000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		240,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		556,734.60
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		00.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		161,432,470.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		161,432,470.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		18,150,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		135,624,200.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		7,658,270.00

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Физик технологийн хүрээлэнгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг захирал П.Алтанцог танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах, ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгаж, тодруулж байх, бараа материалын тооллого хийж, тооцоо бодож байх, тайлант хугацаанд хэвлүүлсэн ном хэвлэлд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах, анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах талаар зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Аккаунт траст аудит ХХК-ийн ахлах аудитор П.Наранцэцэг, чанарын хяналтын менежер Б.Баярмаа нар анхан шатны чанарын хяналтыг, аудитор С.Доржпагма, Б.Эрдэнэчимэг, туслах аудитор П.Саранчимэг нар аудитын гүйцэтгэлийг тус тус хариуцаж хэрэгжүүлэв.

Физик технологийн хүрээлэнгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 01 сарын 22-ны өдрийн 1/04 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Физик технологийн хүрээлэнгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Квант орны онолын судалгаа;
- Их энергитэй эгэл бөөмс, цөмийн харилцан үйлчлэлийн судалгаа;
- Хатуу биеийн физик, функциональ материалын физик технологийн судалгаа;
- Соно ба фотобиофизикийн судалгаа;
- Энергийн альтернатив эх үүсгүүрийн технологи ба цацрагийн физикийн судалгаа;
- Физик электроник, автоматикийн онол, туршилтын ба мэдээллийн технологи, тооцооллын судалгаа.

Физик, технологийн хүрээлэн нь 3 салбар тэдгээрт харьяалагдах 6 лаборатори, салбар дундын 1 лаборатори, 1 төвтэйгээр үйл ажиллагаагаа явуулж, 2020 оны байдлаар нийт 21 төсөл хэрэгжүүлж байна. Үүнд:

- Суурь судалгааны төсөл 11,
- Гадаадтай хамтарсан төсөл 6,
- Шинжлэх ухаан, технологийн захиалгат төсөл 1,
- Технологийн туршилт, зүгшрүүлэлтийн төсөл 1,
- ШУА-ийн грант төсөл 1
- Олон улсын TWAS грант төсөл 1 байна.

Физик технологийн хүрээлэнгийн 2020 оны эрдэм шинжилгээний төлөвлөгөөт ажлыг тоон үнэлгээгээр илэрхийлж, хэвлүүлсэн бүтээл, номын тоогоор үнэлбэл 97.0 хувьтай байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн Газрын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 472 дугаар тогтоол.
- Засгийн Газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 382 дугаар тогтоолын 5-д “Төрийн захиргааны албан хаагчийн нэмэгдэл хөлс, төрийн үйлчилгээний албан хаагчийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн тооцож олгосугай” гэж заасны дагуу нэмэгдэл олгосон.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Физик технологийн хүрээлэнгийн удирдлага санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллага Нягтлан бодох бүртгэлдээ БШУС-ын 2017 оны бодлогын баримт бичиг, журам батлах тухай А/40 дүгээр тушаалаар баталсан сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагад мөрдөгдөх бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байна.

БШУЯамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар 2020 онд тус хүрээлэнгийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Физик технологийн хүрээлэнгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дотоод хяналтыг үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны санхүү байдлын тайлангийн нийт хөрөнгийн 5,631,093.1 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 56,310.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийсэн санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгө 5,475,884.6 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 54,758.8 мянган төгрөгөөр тогтоов.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Физик технологийн хүрээлэнгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 213,437.5 мянган төгрөгөөр буюу 4.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урьдчилж төлсөн тооцоо, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган.төг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	-	714.8	714.8
Урьдчилгаа	-	44,000.0	44,000.0
Бараа материал	199,436.2	222,545.1	23,108.9
Үндсэн хөрөнгө	4,779,265.0	4,924,878.8	145,613.8
Биет бус хөрөнгө	283,745.9	283,745.9	-
Нийт хөрөнгө	5,262,447.1	5,475,884.6	213,437.5
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	5,262,447.1	5,475,884.6	213,437.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	5,262,447.1	5,475,884.6	213,437.5

Авлага дансны үлдэгдэл 714.8 мянган төгрөг байгаа нь суурь судалгааны төслийн 2020 оны дотоод томилолтын үлдэгдэл 556.7 мянган төгрөгт үндсэн үйл ажиллагааны орлогоос эрх нээгдээгүй тул авлага үүсгэсэн, нийгмийн даатгалд 158.1 мянган төгрөгийг илүү төлсөнтэй тус тус холбоотой байна.

Урьдчилан төлсөн тооцоо дансны үлдэгдэл 44,000.0 мянган төгрөг байгаа нь нээлттэй тендер шалгаруулалтаар лабораторийн тоног төхөөрөмж нийлүүлэхээр Оюу энд Эн интенеишнл ХХК-тай 2020.08.24-ны өдөр хийсэн ФТХ /202005001 тоот гэрээгээр нийлүүлэх тоног төхөөрөмжийн тээвэрлэлтэд Ковид 19 цар тахлын улмаас хүндрэл учирч нийлүүлэгдээгүйтэй холбоотой байна. Дээрх төлбөрт Хас банк 2021.12.18-ны өдөр хүртэл хугацаатай {190GT12203500001} тоот урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргасан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 222,545.1 мянган төгрөг болж 23,108.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 63,686.1 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 40,577.2 мянган төгрөгийн зарцуулалттай холбоотой байна.

Бараа материалын үлдэгдлийн 8.69 хувь буюу 17,328.9 мянган төгрөгийн материал, 2020 онд худалдан авсан бараа материалын 35.4 хувь буюу 22,544.1 мянган төгрөгийн материал ашиглагдаж, худалдан авсан бараа материалаас 41,142.0 мянган төгрөгийн материал нэмж нөөцлөгдсөн байна. Хүрээлэнгийн үйл ажиллагааны онцлогтой уялдан дараах шалтгааны улмаас химийн бодис, урвалжийг нөөцлөх шаардлага гардаг байна. Үүнд:

1. Бүх төрлийн органик болон органик биш шингэн бодисуудыг жижиглэн савлаж худалддаггүй;
2. Шинжилгээнд байнга хэрэглэгддэг бодис урвалжууд, зах зээлд бэлэн байдаггүй, захиалан авдаг тул харьцангуй их хэмжээгээр авч, зориулалтын химийн бодисын агуулахад нөөцөлдөг;
3. Эрдэм шинжилгээний туршилтын тоог урьдчилан тодорхойлох боломжгүй тул байнгын нөөцтэй байх шаардлагатай гэх мэт.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,924,878.8 мянган төгрөг болж 145,613.8 мянган төгрөгөөр өссөн байна. Үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг авч үзвэл 491,036.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, ТӨБЗГ-ын 2020 оны А-1/1137 дугаар албан бичиг, 391 дүгээр тогтоолоор 6,444.9 мянган төгрөгийн хөрөнгийг акталсан байна.

Нэмэгдсэн үндсэн хөрөнгийн санхүүжилтийн эх үүсвэрийг авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

- Урсгал төсвийн худалдан авалтаар 1,000.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил;
- Шинжлэх ухаан технологийн сангаас эрдэм шинжилгээний төсөл хэрэгжүүлж, нэмэлт санхүүжилтийн эх үүсвэрээр 60,257.7 мянган төгрөгийн компьютер тоног төхөөрөмж;
- БШУЯ-ны хөрөнгө оруулалтаар үнэ төлбөргүй шилжиж ирсэн 20,875.5 мянган төгрөгийн үнэ бүхий 9 ширхэг компьютер;
- ТӨБЗГ-ын 401 дугаар тогтоолоор элэгдлээрээ анхны өртгөө нөхөж үлдэх өртөггүй болсон 1,212,067.1 мянган төгрөгийн анхны үнэ бүхий хөрөнгийг дахин үнэлж, ашиглалтын хугацааг сунган 408,902.8 мянган төгрөгөөр үнэлэн бүртгэсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 5,475,884.6 мянган төгрөг болж 213,437.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 202,859.4 мянган төгрөгөөр буюу 11.7 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлого байна. Энэ нь Засгийн газрын 2019 оны Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай 472 дугаар тогтоол, 2018 оны 382 дугаар тогтоолын 5-д заасны дагуу цалин, нэмэгдлийн төсвийг нэмж баталсантай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 169,135.7 мянган төгрөгөөр буюу 8.5 хувиар өссөн нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,464,097.8 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 2,464,097.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 689,207.5 мянган төгрөгөөр бууруулж 1,774,890.3 мянган төгрөгөөр баталжээ. Энэ нь улс орны эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан тэвчиж болох зардал гэж тооцон бараа материал, эд хогшил, урсгал засварын зардал, лабораторийн тоног төхөөрөмжийг шинэчлэхтэй холбогдох төсвийг хасч баталсантай холбоотой байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг улсын төсвийн 1,774,890.3 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,774,890.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1,757,831.2 мянган төгрөгийг зарцуулж 17,059.1 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,757,831.2 мянган төгрөг буюу 99.0 хувьтай байгаа нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 48.1 мянган төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 16,581.7 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 310.9 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийг 118.4 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Шинжлэх ухаан технологийн сангаас эрдэм шинжилгээний төслийн санхүүжилтэд 135,624.2 мянга, УБ хотын агаарын бохирдолтой тэмцэх газар, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын захиалгат шинжилгээний ажлын төлбөр 18,150.0 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 7,658.3 мянга, нийт 161,432.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс байр ашиглалттай холбоотой зардалд 1,205.0 мянга, хангамж, бараа материалд 1,182.3 мянга, эд хогшил худалдан авахад 4,055.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрт 154,193.4 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 240.0 мянга, нийт 160,875.7 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 556.8 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Тайлант онд тус хүрээлэнгийн үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого бүрдүүлэлт, зарцуулалт нь Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тогтоолоор баталсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ын холбогдох заалтуудтай нийцэж байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудаст мэдээллийг байршуулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд байгууллагын www.shilendans.gov.mn цахим хуудаст байршуулах 151 мэдээллээс 8 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, мөн 3 мэдээллийг цахим хуудаст байршуулаагүй зөрчилд албан шаардлага өгсөн.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар бараа материалын тооллогын бүртгэлийг баталгаажуулах, албан хаагчдийн хэрэглэж байгаа эд хөрөнгийн ашиглалтын бүртгэлд код, чанар шилжилт хөдөлгөөний мэдээллийг тусгаж, эзэмшигчээр гарын үсэг зуруулах талаар өгсөн 17,100.6 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгснийг 100.0 хувь биелүүлсэн байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт:

/мянган.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	17,100.6	2	17,100.6	-	-	100.0
Нийт дүн	2	17,100.6	2	17,100.6			100.0

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,066,434.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 789,573.5 мянган төгрөгийн алдааг залруулж, 54,316.2 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж, 222,545.1 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлийн дүн ерөнхий журналаас 640,870.5 мянган төгрөгөөр дутуу, машин тоног төхөөрөмжийн элэгдэл 148,544.9 мянган төгрөгөөр дутуу тооцоологдсон байсныг залруулсан.
2. Нийгмийн даатгалд 158.1 мянган төгрөгийг илүү төлсөн боловч санхүүгийн тайланд авлага үүсгээгүй байсныг залруулав.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 276,861.3 мянган төгрөгийн 4 залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 2 зөрчилд албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Санхүүгийн байдлын тайлан дахь 222,545.1 мянган төгрөгийн бараа материалыг 2020 оны жилийн эцэст тооллого хийж, тооцоо бодоогүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-д “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ: 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.2-д “түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс/ тооллого хийх” гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй, үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

2. Тайлант хугацаанд байгууллагын www.shilendans.gov.mn цахим хуудаст байршуулах 151 мэдээллээс 8 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, мөн 3 мэдээллийг цахим хууласт байршуулаагүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.4-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: 6.4.5 “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Төрийн аудитын тухай хуулийн 21 дугаар зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1-д заасныг тус тус үндэслэн албан шаардлага хүргүүлэв.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 54,316.2 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаатай холбоотой аудит хийх цар хүрээ хязгаарлагдаж, байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэн, анхан шатны баримт материалуудыг бүрэн хамруулж, хөрөнгийн биет тооллого хийх, цалин хөлсний тушаал шийдвэр гэх мэт төсвийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Балансын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тайлант онд хэвлэсэн 8,625.1 мянган төгрөгийн номыг шууд зардлаар бүртгэж Захирлын тушаалын дагуу эрдэм шинжилгээний байгууллага, их дээд сургуулиудад өгсөн гэх боловч анхан шатны баримтаар баталгаажуулаагүй байна. Энэ нь “иж бүрэн байх”, “үнэн зөв байх” батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

1.2. Эрсдэл:

Хөрөнгөд бүртгэлээр тавих хяналтыг сулруулах.

1.3. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэж заасныг зөрчсөн. Хэвлэсэн ном, бүтээлийг бараа материалд орлого авч байх, анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлж, бүртгэж байх.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг биелүүлж ажиллана.

2. Балансын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Тайлант онд 79 аж ахуйн нэгжтэй хийсэн 359,075.6 мянган төгрөгийн худалдан авалтыг И-баримттай тулган шалгахад 14 аж ахуйн нэгж байгууллагын 45,691.1 мянган төгрөгийн зарим худалдан авалт болон ажил үйлчилгээний төлбөрийг И баримтгүй (бэлтгэн нийлүүлэгч байгууллага И баримтыг цахим системд дутуу бүртгүүлсэн) шилжүүлсэн нь “иж бүрэн байх”, “үнэн зөв байх” батламж мэдэгдэлтэй нийцээгүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.4-д “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

2.2. Эрсдэл:

Хөрөнгөд бүртгэлээр тавих хяналтыг сулруулах.

2.3. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэж заасныг зөрчсөн байна. Хуульд заасны дагуу анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлж, бүртгэлд тусгаж байх.

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг биелүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Физик технологийн хүрээлэнгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			САГ-2020/85/СТА-
Шалгагдсан байгууллагын нэр:	Физик технологийн хүрээлэн		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Бараа материалын жилийн эцсийн тооллого хийж, тооцоо бодоогүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-д “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ:12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.2-д “түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1,12 дугаар сарын 1-нээс/ тооллого хийх” гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.	222,545.1	Албан шаардлага	Захирал Нягтлан бодогч	П.Алтанцог А.Алтайсайхан
2	Тайлант хугацаанд байгууллагын www.shilendans.gov.mn цахим хуудаст байршуулах 151 мэдээллээс 8 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, мөн 3 мэдээллийг цахим хуудаст байршуулаагүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 6 дугаар зүйлийн 6.4-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: 6.4.5 “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр,” гэж заасныг тус тус зөрчсөн байна.		Албан шаардлага	Захирал Нягтлан бодогч	П.Алтанцог А.Алтайсайхан
3	Тайлант онд хэвлэсэн 8,625.1 мянган төгрөгийн номыг шууд зардлаар бүртгэж Захирлын тушаалын дагуу эрдэм шинжилгээний байгууллага, их дээд сургуулиудад өгсөн гэх боловч анхан шатны баримтаар баталгаажуулаагүй байна.	8,625.1	Зөвлөмж	Захирал Нягтлан бодогч	П.Алтанцог А.Алтайсайхан
4	Тайлант онд 79 аж ахуйн нэгжтэй хийсэн 359,075.6 мянган төгрөгийн худалдан авалтыг И-баримттай тулган шалгахад 14 аж ахуйн нэгж байгууллагын 45,691.1 мянган төгрөгийн зарим худалдан авалт болон ажил үйлчилгээний төлбөрийг И баримтгүй (бэлтгэн нийлүүлэгч байгууллага И баримтыг цахим системд дутуу бүртгүүлсэн) шилжүүлсэн.	45,691.1	Зөвлөмж	Захирал Нягтлан бодогч	П.Алтанцог А.Алтайсайхан
ДҮН		276,861.3			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25 № 175/А0160058
СНГ-2021/85/СТА-ТМЗ
Зөрчил арилгуулах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Физик технологийн хүрээлэнгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд байгууллагын www.shilendans.gov.mn цахим хуудаст байршуулах 151 мэдээллээс 8 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, мөн 3 мэдээллийг цахим хуудаст байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:", 6.4.5 "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж мэдээллийг ил тод, цаг хугацаанд нь бүрэн байршуулж, биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Физик технологийн хүрээлэнгийн Захирал П.Алтанцог, Нягтлан бодогч А.Алтайсайхан нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЕРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АХЛАХ АУДИТОР
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ.
АККАУНТ ТРАСТ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.СЭРЖМЯДАГ

П.НАРАНЦЭЦЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban-Shaardlaga\2021\0225auditin 2-R Gazar139.Docx

[illegible]

This image shows a full page of a handwriting practice worksheet. It consists of approximately 28 horizontal rows. Each row is defined by two parallel dotted lines, creating a series of uniform gaps for letter height. The entire page is otherwise blank, with no margins, text, or other markings.

[illegible]